



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/166

Булган сум

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX Хуралдааны XIX/08 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ойн сангийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах зорилтын хүрээнд “Хожуул” төслийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах 30,000,000 (гучин сая) төгрөгийн эрхийг Булган сумын Засаг дарга (П.Нөхөрлөлбаяр)-д шилжүүлсүгэй.

2.Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх талбайн тусгаарлалтыг мэргэжлийн байгууллагаар хийлгэн, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлыг сайтар хангаж ажиллахыг дээрх сумын Засаг даргад үүрэг болгосугай.

3.Дээрх ажилд шаардлагатай санхүүжилтийг Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний “Хожуул” төслийг хэрэгжүүлэх (Булган сум) арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

4.“Хожуул” төслийг хэрэгжүүлэхэд мэргэжлийн болон арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (А.Гантөмөр)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ

